



ХӨВСГӨЛ АЙМАГ
ЦАГААН-УУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 44

Шарга

Шагналд дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ыг үндэс тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Үйлчилгээний салбарт олон жил идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан Жаргалант багийн өндөр настан Балганы Нямжавыг "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон" –оор,

2. Төр захиргаа, Боловсрол, Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт олон жил идэвхи зүтгэл үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан тус сумын Өвгөд багийн өндөр настан Балдангийн Жамбалсүрэн, Дэлэгийн Эрдэнэ-Төгс, Гэндэнгийн Наранцог, Шарга багийн өндөр настан Даваажавын Мягмар, Жаргалант багийн өндөр настан Өнөрийн Амаржаргал, Даваадоржийн Загдрагчаа, Гордоон Далхсүрэн, Цэрэнбалдирын Нямдаш нарыг "Алтан гадас одон"-оор, Өвгөд багийн өндөр настан Пүрэвсамбын Мөнх-Эрдэнэ, Жамбаан Мягмар, Жамбалдоржийн Хүрэлбаатар, Жаргалант багийн өндөр настан Тумбаашын Баасанжав, Гэндэнгийн Цэдэнсодном, Нацагийн Доржханд, Тумбаан Цэндээ, Гомбожавын Цэрэндорж, Очирбатын Чогжмаа, Дэндэвийн Цэрэнням, Гэндэнгийн Дашцэрэн, Даваадоржийн Бүтэд нарыг "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар тус тус шагнуулах тухай тодорхойлолтыг дэмжин аймгийн Засаг дарга /А.Эрдэнэбаатар/-д уламжилсугай.

3. Шагналд нэр дэвшигчийн тодорхойлт, холбогдох материалыг бүрдүүлж хүргүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/- д даалгасугай.

ДАРГА  Ч.АЗБАЯР